

**ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ
ЗҮЙЛ /АЛБАНЫ НУУЦТАЙ ХОЛБОГДОХ ЗОХИЦУУЛАЛТИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

2025 он

Агуулга

ТАНИЛЦУУЛГА.....

НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ.....

1.1.Үнэлгээ хийх шалтгаан

1.2.Үнэлгээ хийх хүрээ

1.3.Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

1.4.Үнэлгээний харьцуулах хэлбэр

1.5.Шалгуур үзүүлэлтийг томъёолох

1.6.Мэдээлэл цуглуулах

ХОЁР.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.4.1-д “төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлж, төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно” гэж заасан.

Иймд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн зарим зүйл буюу албаны нууцын талаарх зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв.

Энэхүү үнэлгээний зорилго нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтэд гарч буй хүндрэл, эерэг, сөрөг байдлыг тогтоох, иргэд, олон нийтийн мэдэх эрхэд үзүүлж буй нөлөөллийн талаар дүгнэлт гаргах, цаашид хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, зөвлөмж өгөхөд оршино.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д заасан төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үе шатын дагуу хийсэн болно.

НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож, түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэхүү төлөвлөх шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- 1.үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- 2.үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- 3.шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- 4.харьцуулах хэлбэрийг сонгох;
- 5.шалгуур үзүүлэлтийг томъёолох;
- 6.мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1.Үнэлгээ хийх шалтгаан:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасны дагуу Улсын Их Хурлаас 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Төрийн болон албаны нууцын тухай хуулийг баталсан бөгөөд уг хуулиар Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах үндэсний тогтолцоо, эрх зүйн үндсийг тодорхойлж, мэдээллийг нууцлах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа билээ.

Тус хуульд нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. Тодруулбал, 2020-2022 оны хооронд Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-иуд батлагдсантай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн албаны нууцтай холбоотой зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт судалгаа хийх дараах үндэслэл байна:

1.“Транспаренси Интернэшнл” олон улсын байгууллагаас жил бүр гаргадаг Авлигын төсөөллийн индексийн оноогоор 180 орноос Монгол Улс 2017 онд 36 оноо авч 103, 2018 онд 37 оноо авч 93, 2019 онд 35 оноо авч 106, 2020 онд 35 оноо авч 111, 2021 онд 35 оноо авч 110, 2022 онд 33 оноо авч 116, 2023, 2024 онуудад мөн 33 оноогоор 121, 116 дугаар байрт тус тус эрэмбэлэгдэж, жил бүр ухарсаар байна.

Түүнчлэн, “Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Ерөнхий сайдын 2025 оны 64 дүгээр захирамжийн 1 дүгээр зүйлд Монгол Улсын авлигын төсөөллийн индексийн оноо, эрэмбэ сүүлийн жилүүдэд тогтмол буурахад нөлөөлж

буй хүчин зүйлсийг тодорхойлж, “Транспаренси Интернэшнл” олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр даалгасан;

2.Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг баталсан бөгөөд хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д “хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг албаны нууцад хамааруулж тогтоохгүй”, 8 дугаар зүйлийн 8.1-д “төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана” гэж заасан;

2.Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023–2030 он/-ийн 10.1.1-д “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа болон хуулиар төрийн нууцад хамааруулснаас бусад мэдээллийг ил тод болгож, түүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ” гэж заасан;

3.Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.4.1-д “төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлж, төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно” гэж заасан.

Иймд дээр дурдсан хууль, тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн албаны нууцын тухай хуулийн албаны нууцтай холбоотой зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт судалгаа хийв.

1.2.Үнэлгээ хийх хүрээ

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дараах хүрээнд үнэлгээг хийх нь зүйтэй байна:

- 1.Албаны нууцын ойлголт, түүний хүрээ;
- 2.Мэдээллийг албаны нууцад хамааруулах шалгуур, нууцлах үндэслэл;
- 3.Албаны нууцад хамаарах мэдээллийг ил болгох асуудал.

Тодруулбал, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалт үнэлгээ хийх хүрээнд хамаарна:

№	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн зүйл	Зүйлийн доторх хэсэг, заалтын агуулга
1.	5 дугаар зүйл	5.1.2."албаны нууц" гэж задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага,

		бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг;
2.	14 дүгээр зүйл	14.1.Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална. 14.2.Энэ зүйлийн 14.1-д заасан жагсаалтыг батлахад тагнуулын байгууллагын саналыг авна.
3.	16 дугаар зүйл.	16.6.Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага бусад хуулийн этгээдийн ашиг сонирхол, үйл ажиллагаанд хохирол учруулах, эсхүл төрийн нууцад хамаарах мэдээллийг задруулах нөхцөл бий болгох мэдээллийг "нууц" зэрэглэлд хамааруулна. 16.7.Төрийн болон албаны нууцын зэрэглэлийг тогтоох журмыг Засгийн газар батална.
4.	17 дугаар зүйл	17.1.3."нууц" зэрэглэлд хамаарах мэдээлэл-10 жил.
5.	19 дүгээр зүйл	19.1.Төрийн болон албаны нууцыг дараахь үндэслэлээр ил болгоно: <u>19.1.2.нөхцөл байдал өөрчлөгдсөний үлмээс төрийн болон албаны нууцад хамааруулсан тодорхой мэдээллийг цаашид нууцлах шаардлагагүй болсон;</u> 19.3.Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг энэ зүйлийн 19.1.2-т заасан үндэслэлээр нууцлах хугацаа дуусахаас өмнө ил болгох эсэхийг тагнуулын байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ. 19.6.Төрийн болон албаны нууцыг ил болгох журмыг Засгийн газар батална.

1.3.Үнэлгээний шалгуур үзүүлэлт:

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д заасны дагуу өмнөх шатанд сонгосон Төрийн болон албаны нууцын тухай хуулийн албаны нууцтай холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн байдлыг үнэлэхдээ “практикт нийцэж байгаа байдал (&3.4.5.)” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгов. Уг шалгуур үзүүлэлтийн дагуу дараах асуудлыг тогтооно:

-тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

Түүнчлэн, хууль хэрэгжиж эхэлснээс хойш гарсан зардлыг тооцоолох боломжгүй тул зардлын өсөлт, бууралт болон зардал-үр өгөөжийн харьцаа гэсэн шалгуур үзүүлэлтийг хэрэглэх нь үр дүнгүй гэж үзлээ.

1.4.Үнэлгээний харьцуулах хэлбэр:

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд заасан 4 төрлийн харьцуулах хэлбэрүүдээс “хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш (&3.5.3.3)¹” болон “тохиолдол судлах (&3.5.3.4)” хэлбэрүүдийг сонголоо.

Тухайлбал, үнэлгээний шалгуур үзүүлэлтээр “практикт нийцэж байгаа байдал (&3.4.5.)²” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгосон тул үүнтэй уялдуулан дээрх харьцуулах хэлбэрийг сонгосон болно.

1.5.Шалгуур үзүүлэлтийг томьёолох:

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд шалгуур үзүүлэлтийг томьёолох гэдэг нь тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглалыг дэвшүүлэх, эсхүл асуулт тавихыг хэлэхээр заасан.

Энэхүү үнэлгээнд “практикт нийцэж байгаа байдал (&3.4.5.)” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгосон бөгөөд шалгуур үзүүлэлтүүдийг томьёолохдоо дараах асуултыг боловсрууллаа:

1.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн албаны нууцтай холбоотой зохицуулалтууд практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хүндрэл бэрхшээл үүсгэж байгаа эсэх?

2.Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан албаны нууцын зохицуулалтууд иргэд, олон нийтийн мэдэх эрхийг зөрчиж байгаа эсэх?

1.6.Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн албаны нууцтай холбоотой зохицуулалтуудын хүлээн зөвшөөрөгдсөн болон практикт нийцэж байгаа байдлыг судлах зорилгоор хүчин төгөлдөр мөрдөж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, судалгааны ажлын тайлан унших, харьцуулалт хийх зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ.

¹ хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтооход чиглэгдэнэ. Тодорхой цаг хугацааны дарааллаар нөхцөл байдлын өрнөлийг жагсааж гаргасан судалгааг үнэлгээнд хэрэглэнэ.

² тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу “бэлэн байгаа мэдээллийг цуглуулах” хүрээнд холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ, судалгааны ажил болон Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийсэн болно.

ХОЁР.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн албаны нууцын тухай зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ бэлэн байгаа дараах мэдээлэлд үндэслэн үнэлгээ хийсэн болно:

-Монгол Улсын Үндсэн хууль;

-Улсын Их Хурлаас 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хувийн хэрэг;

-Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай /шинэчилсэн найруулга/ хууль;

-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай;

-Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023–2030 он/”;

-Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;

-“Транспаренси Интернэшнл” олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмж;

-“Ес.Төрийн болон албаны нууцын эрх зүйн зохицуулалт: Олон улсын чиг хандлага, зарим улсын туршлага” сэдэвт харьцуулсан судалгааны ажил.” Судалгааны тайлангийн эмхэтгэл XVII боть (2024 он),

ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Энэхүү үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлт, томъёоллын дагуу Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан албаны нууцын зохицуулалтын хэрэгжилтийг үнэлж, дүгнэлт гаргалаа.

3.1.Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах тогтолцоо, эрх зүйн үндэс 1995 онд батлагдсан Төрийн нууцын тухай хуулиас эхтэй бөгөөд тус хуульд 2001, 2003, 2004, 2014 онуудад буюу нийт 5 удаа нэмэлт, өөрчлөлт орж байжээ.

Харин одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Төрийн болон албаны нууцын тухай хуулийг “улсын хэмжээнд төрийн нууцыг хадгалах, хамгаалах ажил хангалтгүй, түүнчлэн гадаад орнуудын төрийн нууцыг хамгаалах арга, хэлбэрт өөрчлөлт орж байгаатай холбогдуулан төрийн болон албаны нууцын асуудлыг шинэ зарчим, хандлагаар авч үзэж Төрийн нууцын тухай болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг нэгтгэн төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллүүд, байгууллага, албан тушаалтны бүрэн

эрхийг тодорхой хуульчлах, мэдээлийг нууцлах, ил болгох оновтой зохицуулалтыг бий болгох, иргэний мэдээлэл авах эрхийг хангах, төрийн болон албаны нууцыг хамгаалах олон талт арга хэмжээг бүрэн тусгах, нууцын хамгаалалтад тавих хяналт, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг боловсронгуй болгох” гэсэн үзэл баримтлалыг баримтлан боловсруулж байжээ.

Гэвч Улсын Их Хурлын Тамгын газарт хадгалагдаж байгаа Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хувийн хэргээс үзвэл, ямар улсын төрийн нууцын хууль тогтоомжийг харьцуулан судалсан эсэх материал байхгүй байгааг дурдах нь зүйтэй байна.

3.2. Улсын Их Хурлаас 1995 онд батлан мөрдүүлж байсан Төрийн нууцын тухай хуульд “албаны нууц” гэх ойлголтыг хуульчлаагүй бөгөөд уг ойлголт одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа Төрийн болон албаны нууцын тухай хуульд хуульчлагдан мөрдөж байна. Тухайлбал,

Хуулийн 5.1.2-т ““албаны нууц” гэж задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг” ойлгохоор, 17 дугаар зүйлийн 17.1.3-т “Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага бусад хуулийн этгээдийн ашиг сонирхол, үйл ажиллагаанд хохирол учруулах, эсхүл төрийн нууцад хамаарах мэдээллийг задруулах нөхцөл бий болгох мэдээллийг “нууц” зэрэглэлд 10 жилийн хугацаатай төрийн хамгаалалтад байхаар заасан.

Уг заалтын хүрээнд “салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг” албаны нууцад хамруулах болсноор төрөөс нууцлах мэдээллийн төрөл, хэмжээ, агуулгыг хэт ихэсгэж, энэ хэрээр иргэнд нээлттэй байх мэдээллийг багасгасан гэж үзэхээр байна.

Түүнчлэн, хуульд “албаны нууц”-ын талаарх ойлголтыг хэт өргөн, явцуу хүрээнд хуульчилсны улмаас манай улс 2025 оны байдлаар **62 төрийн байгууллагын 928 албаны нууцтай**³ болсон байх бөгөөд уг хуулийн зохицуулалт хэвээр мөрдөгдөх тохиолдолд уг нууцын тоон мэдээлэл цаашид улам нэмэгдэж, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д заасан “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.” гэж заасан Монгол Улсын иргэдийн үндсэн эрх зөрчигдөж болзошгүй байна.

Түүнчлэн, 2025 онд Тагнуулын ерөнхий газраас хуульд заасан чиг үүргийнхээ дагуу **59** төрийн байгууллагын **нийт 882** албаны нууцад хяналт шалгалт хийсэн бөгөөд үүнээс 69 хувь нь буюу 608 мэдээлэл нь хуульд заасан шалгуурыг хангаж, харин **31 хувь буюу 274 мэдээллийг үндэслэлгүйгээр нууцалсан** зөрчил илэрчээ.⁴

Мэдээллийн хүрээгээр ангилсан тоон үзүүлэлтийг харуулбал,

№	Албаны нууцын мэдээллийн хүрээ	Мэдээллийн тоо
---	--------------------------------	----------------

³ Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн судалгааг хавсаргав.

⁴ Тагнуулын ерөнхий газрын 2025 оны ТЕ01/355 дугаартай албан бичгийг хавсаргав.

1.	Байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамаарсан мэдээлэл	335
2.	Цахим сан, түүнд холбогдох мэдээлэл	41
3.	Цахим орчны аюулгүй байдал хангахтай холбоотой мэдээлэл	95
4.	Нууц хадгалах, хамгаалах зорилготой баримт бичгийн шинжтэй мэдээлэл	357
5.	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар зохицуулагдсан хувь хүний мэдээлэл	54

Мөн албаны нууцад хамаарах мэдээллүүд нь Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т “байгууллагын нууц” гэж хүний эрх, нэр төр, алдар хүнд тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ” гэж заасантай давхардал үүсгэж байна.

3.3. Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг баталсан бөгөөд хуульд дараах онцлог зохицуулалтыг тусгасан. Үүнд:

-Нийтийн мэдээлэл буюу төрд байгаа мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай гэж ангилсан. Хаалттай мэдээлэлд төрийн нууц болон хуулиар хаалттай гэж тогтоосон мэдээллийг, хязгаарлалттай мэдээлэлд албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах, зөвшөөрлийн үндсэн дээр хандаж, ашиглаж болох мэдээллийг ойлгохоор тусгасан;

-Төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд таван ангиллын 68 төрлийн байнга нээлттэй, хаалттай, хязгаартайгаас бусад мэдээллийг нээлттэй байхаар тусгасан бөгөөд нээлттэй байхаар заасан мэдээллийг цаашид албаны нууцад хамааруулж болохгүй гэж заасан.

Гэвч Нийтийн мэдээллийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д “хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг албаны нууцад хамааруулж тогтоохгүй” гэж заасныг зөрчиж, нээлттэй байх мэдээллийг нууцалсныг Тагнуулын ерөнхий газрын хяналт шалгалтын тайланд дурдсан байна.

3.4. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална” гэж, 14.2-т “энэ зүйлийн 14.1-д заасан жагсаалтыг батлахад тагнуулын байгууллагын саналыг авна” гэж заасны дагуу мэдээллийг Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр албаны нууцад авдаг.

Засгийн газрын 2017 оны 09 дүгээр тогтоолын 12-ны өдрийн 246 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 3.5.2-т “байгууллага өөр дээрээ хадгалагдаж байгаа нууц баримт бичиг, бусад тээгчийн хадгалах бүх хугацаанд хяналт тавих бөгөөд тэдгээрийг ил болгох, эсхүл нууцлах хугацааг сунгах эсэх асуудлыг тухайн байгууллагын удирдлага Төрийн болон албаны нууцын тухай хууль, энэхүү журамд заасны дагуу шийдвэрлэнэ” гэж заасан.

Өөрөөр хэлбэл, уг үйл ажиллагаанд Засгийн газар аливаа хэлбэрээр оролцдоггүй болно.

Энэ нь тухайн байгууллагын удирдлага хуульд заасан “задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага бусад хуулийн этгээдийн ашиг сонирхол, үйл ажиллагаанд хохирол учруулах” гэсэн хэт өргөн хүрээгээр томъёолсон шаардлага, агуулгад үндэслэн аливаа мэдээллийг албаны нууцад авах нөхцөл үүсгэж байна.

Үүнтэй холбогдуулан авлига, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг гарах, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль зөрчигдөх, иргэд, олон нийтийн мэдээлэл авах эрх зөрчигдөх нөхцөл бүрдэж байна.

3.5. Бусад улсын төрийн болон албаны нууцын зохицуулалтын тухай:

Судалгааны хүрээнд Оросын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс (Өмнөд Солонгос), Америкийн Нэгдсэн Улс, Их Британи, Япон улсын жишээн дээр тулгуурлан **төрийн нууц** (улсын аюулгүй байдал, батлан хамгаалах чадавх, гадаад харилцаа, тагнуулын ажиллагаатай шууд холбогдох, задруулбал ноцтой хохирол учруулж болзошгүй мэдээлэл) болон **албаны нууц** (төрийн байгууллага дотоод зохион байгуулалт, хүний нөөц, санхүү, төлөвлөлт зэрэг зөвхөн албаны хэрэгцээнд ашиглагдах мэдээлэл) хэмээх ойлголтын талаар судлав.

ОХУ (ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС): Оросын Холбооны Улсад **“төрийн нууц”** (*государственная тайна*) нь задруулбал улсын аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй мэдээллийг хамарна. Энэ хүрээнд цэрэг, гадаад бодлого, тагнуул, стратегийн эдийн засгийн мэдээлэл зэрэг хуульд тодорхой заасан салбарын мэдээлэл ордог. Харин төрийн байгууллагын дотоод мэдээлэл — тухайлбал дотоод журам, хүний нөөцийн баримт, санхүүгийн мэдээлэл, төлөвлөгөө — нь ихэвчлэн **“албаны нууц”** гэсэн ангилалд орж, баримт бичиг дээр **“Для служебного пользования (ДСП)”** гэж тэмдэглэгддэг. Энэ ангилал нь зөвхөн байгууллагын дотоод хэрэгцээнд ашиглагдах бөгөөд *төрийн нууцыг хуулиар хамгаалахтай дүйцэхгүй*, өөрөөр хэлбэл нууцын зэрэглэлийн доод түвшинд тооцогдоно.

ОХУ-ын **“Төрийн нууцын тухай хууль” (1993)**-д ямар мэдээллийг төрийн нууцад хамруулах, эс хамруулахыг нарийвчлан тогтоосон. Жишээлбэл, иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэнд, эрх чөлөө, байгаль орчны мэдээллийг төрийн нууцад оруулахыг хориглодог. Төрийн нууцын хүрээг хуульд заасан журмаар Засгийн газар болон холбогдох байгууллагууд тогтоон, жагсаалт гаргадаг. Харин **албаны нууц (ДСП)**-ын тухайд Засгийн газрын **1994 оны 1233-р тогтоол**-оор журамлаж, байгууллагууд өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн ямар мэдээлэлд “зөвхөн албаны хэрэгцээнд” гэсэн тэмдэглэгээ тавихыг шийдвэрлэдэг. Эрх бүхий албан тушаалтан уг шийдвэрийг гаргаж, үндэслэлгүйгээр мэдээллийг ДСП ангилалд оруулсан нь тогтоогдвол тухайн албан тушаалтанд хариуцлага тооцох механизмыг журамласан байдаг.

Албаны нууц задруулсан тохиолдолд эрүүгийн хариуцлага ерөнхийдөө хүлээлгэдэггүй. Гэхдээ **Захиргааны зөрчлийн тухай хууль**-д зааснаар торгууль ногдуулах, мөн **Хөдөлмөрийн хууль**-д заасан үндэслэлээр тухайн ажилтныг

ажлаас чөлөөлөх зэрэг сахилгын хариуцлага хүлээлгэх боломжтой. Харин төрийн нууц задруулсан бол Эрүүгийн хуульд зааснаар эрүүгийн ял шийтгэл оногдуулна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс: Герман Улс төрийн мэдээллийн нууцлалын дөрвөн шатлалтай систем хэрэглэдэг. Үүнд: **онц нууц** (*Streng Geheim*), **нууц** (*Geheim*), **итгэмжлэгдсэн нууцлалтай** (*VS-Vertraulich*), болон хамгийн доод түвшин болох **зөвхөн албаны хэрэгцээнд** (*VS-NfD – Nur für den Dienstgebrauch*) ангилал орно. Дотоод шинжтэй ихэнх баримт бичиг, албан захидал, төлөвлөгөө зэрэг нь хэрэв задруулбал улсын ашиг сонирхолд зөвхөн *бага зэргийн хохирол* учруулж болзошгүй тохиолдолд хамгийн доод түвшинд, өөрөөр хэлбэл “**зөвхөн албаны хэрэгцээнд**” гэсэн тэмдэглэгээтэйгээр хамгаалагддаг.

Энэхүү зохицуулалт нь Монгол Улсын “**Төрийн болон албаны нууцын тухай хууль**”-ийн 3 дугаар зүйлд заасан *албаны нууц* ангилалтай дүйцэх бөгөөд нууцын ангиллын хамгийн анхан шатны түвшинд тооцогддог. Харин мэдээллийн шинж чанар нь улс орны бүрэн эрхт байдал, батлан хамгаалах чадавхи, үндэсний аюулгүй байдал, гадаад харилцаанд илүү ноцтой нөлөөлөхүйц бол шатлан дээшлэх зарчмаар **нууц**, **маш нууц**, цаашлаад **онц нууц** зэрэглэлд шилжиж, өндөр хамгаалалттай эрх зүйн дэглэмд хамаарна.

Германы нууцын зэрэглэлийн тогтолцоо нь Холбооны Засгийн газрын баталсан **нэгдсэн бодлого, журам** болон **Мэдээллийн аюулгүй байдлын холбооны алба (BSI)**-ны шаардлагад тулгуурладаг. Мэдээллийг задруулсан тохиолдолд улс, нийгэмд учирч болзошгүй хор хохирлын хэмжээг харгалзан дээрх ангилал тогтоогдоно. Жишээлбэл, мэдээлэл задрах нь улсын бүрэн эрхт байдал, батлан хамгаалах чадавх, үндэсний аюулгүй байдалд *маш ноцтой хохирол* учруулж болзошгүй бол уг мэдээллийг “**онц нууц**” ангилалд багтаана. Харин хууль зүйн үр дагавар харьцангуй бага, албаны шинжтэй мэдээлэл нь зөвхөн дотоод хэрэгцээнд хязгаарлагдаж, **албаны нууц** буюу хамгийн доод ангиллын хүрээнд хадгалагдана. Германд төрийн байгууллагууд мэдээлэлд нууцын ангилал тогтоохдоо дур мэдэн шийдвэр гаргах боломжгүй бөгөөд улсын хэмжээний нэгдсэн бодлого, хууль болон Засгийн газрын тогтоосон **тогтсон шалгуур, зааврын дагуу** нууцын тэмдэглэгээ, тамга хэрэглэдэг эрх зүйн журам үйлчилдэг. Иймд нууцын зэрэглэл тогтоох нь байгууллагын дотоод шийдвэр бус, харин хууль зүйн үндэслэлтэйгээр төрийн хэмжээнд тогтоогдсон журамд захирагддаг.

Мөн Германы “**Төрийн албан хаагчдын тухай хууль**”-д төрийн албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэх явцдаа мэдсэн *албаны нууцыг хадгалах үүрэгтэй* гэж тодорхой заасан байдаг. Хэрэв төрийн албан хаагч энэ үүргээ зөрчиж, нууц мэдээллийг задруулснаар олон нийтийн ашиг сонирхолд ноцтой хохирол учруулах нөхцөл бүрдвэл, уг үйлдлийг Эрүүгийн хуульд заасан “**албаны нууц задруулсан**” **гэмт хэрэг** гэж тооцож, тав хүртэл жилийн хорих ял оногдуулна. Ийнхүү Герман Улсад дотоод мэдээллийн нууцлалыг байгууллагууд дур зоргоор бус, харин хууль, Засгийн газрын нэгдсэн журамд тулгуурлан тогтоож, зөрчсөн тохиолдолд эрүүгийн болон сахилгын хатуу хяналт, хариуцлага хэрэгждэг.

Германд “**албаны нууц**” (*Dienstgeheimnis*) гэх ойлголт хуульд байдаг бөгөөд энэ нь төрийн албан хаагчийн ажлын байрны нууцыг хадгалах үүрэг, хариуцлагыг илэрхийлдэг. Төрийн байгууллагын дотоод мэдээллийг хамгаалах хууль ёсны үндэслэл нь энэ үүрэгт суурилдаг. Мөн нууцалсан баримт бичигт тавих тэмдэглэгээ нь тухайн мэдээллийн нууцын түвшинг шууд илэрхийлдэг. Жишээлбэл, Германд дотоод мэдээллийг “албан хэрэгцээнд” гэх тусгай нэршилд бус, харин нууцын

шатлалын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болгон ойлгож, мэдээллийн нууцлалыг төрийн албан хаагчдын хуульчилсан үүргээр баталгаажуулдаг.

ИХ БРИТАНИ: Их Британийн Засгийн газар 2014 оноос эхлэн шинэчилсэн **“Засгийн газрын аюулгүй байдлын ангиллын бодлого”**-ыг мөрдөж байгаа. Энэ системийн дагуу төрийн бүх байгууллага нэгдсэн гурван ангиллыг ашиглана: **“Official”** (албан), **“Secret”** (нууц), **“Top Secret”** (маш нууц). Эдгээр нь улс даяар нэг мөр хэрэглэгдэх бөгөөд “Official” ангилал нь хамгийн доод түвшин буюу төрийн байгууллагын өдөр тутмын албан мэдээлэлд хамаардаг гэж бодлогод тодорхой заасан.

Мэдээллийн нууцлал, хамгаалалтын бодлогыг төвлөрүүлэн боловсруулах эрх мэдлийг Засгийн газрын Тамгын газар (**Cabinet Office**) хэрэгжүүлдэг. Үндэсний түвшний **аюулгүй байдлын бодлогын хүрээ баримт бичиг** нь бүх яам, агентлагийн баримтлах суурь журам болж, байгууллагууд өөрсдийн дотоод хэрэгжүүлэх журам, арга хэмжээг боловсруулж болох ч ангиллын нэр, түвшнийг дур мэдэн өөрчлөх боломжгүй. Өөрөөр хэлбэл, “Secret” эсхүл “Top Secret” ангилал олгох шалгуурыг байгууллага тус бүр өөрсдийнхөөрөө тогтоох боломжгүй бөгөөд Засгийн газрын нэгдсэн бодлого, журамд заасан шалгуурт тулгуурлан ангиллыг тогтоодог.

Мөн **Олон нийтийн албаны нууцын гарын авлага** (*Civil Service Code*) болон холбогдох зааварт төрийн албан хаагчид албан үүргийн хүрээнд олж мэдсэн мэдээллээ зөвшөөрөлгүйгээр задруулахгүй байх хуульчилсан үүрэгтэй гэж тодорхой заасан. Их Британийн 1989 оны **“Албаны нууцын тухай хууль”** (*Official Secrets Act 1989*) нь төрийн албан хаагч болон засгийн газрын гэрээт этгээд албан үүргийнхээ хүрээнд олж мэдсэн тодорхой төрлийн мэдээллийг — тухайлбал, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, тагнуулын ажиллагаа, олон улсын харилцааны нууц мэдээллийг — хууль бусаар задруулсан тохиолдолд эрүүгийн гэмт хэрэгт тооцно гэж хуульчилсан байдаг. Энэхүү хууль нь нууцад хамаарах мэдээллийн хүрээ болон *тодорхой төрлийг* зааж өгсөн бөгөөд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн баримт, тагнуулын эх сурвалж болон арга ажиллагаа, зэвсэглэлийн талаарх мэдээлэл, төрийн албаны албан ёсны баримт бичгийг задруулах гэсэн ангиллаар тусгайлан хамгаалагдана.

Иймд Их Британид мэдээлэлд нууцын зэрэглэл олгох ажиллагаа нь Засгийн газрын гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд явагддаг боловч уг мэдээллийг хууль бусаар задруулсан тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь 1911, 1920, 1939 болон 1989 оны “Албаны нууцын тухай хууль” (*Official Secrets Acts*) зэрэг тусгай хууль тогтоомжийн дагуу хэрэгжинэ гэж үзэж болно.

Их Британид “Official secret” буюу “албаны нууц” гэсэн нэр томъёо хууль эрх зүйн утгаараа дээр дурдсан хуулиудад туссан байдаг. Гэвч эдгээр хууль нь мэдээллийг ангилах журам тогтоох зорилготой бус, харин мэдээлэл задруулсан тохиолдолд хүлээлгэх ял шийтгэлийг зохицуулдаг. 2018 онд шинэчлэл хийх талаар хэлэлцэгдсэн ч өнөөгийн байдлаар 1989 оны “Албаны нууцын тухай хууль” хүчин төгөлдөр үйлчилж байна.

Харин байгууллагуудын өдөр тутмын мэдээллийн хамгаалалт нь Засгийн газрын Аюулгүй байдлын ангиллын бодлогоор зохицуулагдаж, дотооддоо “Official” гэх тэмдэглэгээг хэрэглэснээр хэрэгждэг. Тус мэдээллүүд нь улсын аюулгүй байдалд өндөр ач холбогдолтой бол шууд “Secret” эсхүл “Top Secret” ангилалд шилжиж, дээрх Албаны нууцын тухай хууль-ийн хамгаалалтад хамаарна.

Дээр үзүүлсэнчлэн, улс орнууд байгууллагын дотоод албаны мэдээллийг ихэвчлэн улсын нууцын ангиллаас доогуур түвшинд буюу “зөвхөн албан хэрэгцээнд” хамаарах **албаны нууц** гэсэн дотоод хамгаалалтын хүрээнд ангилан хамгаалдаг. Монгол Улсад энэ зохицуулалт нь “**Төрийн болон албаны нууцын тухай хууль**” болон холбогдох Засгийн газрын журамд нийцэн хэрэгждэг бөгөөд байгууллага дур мэдэх бус, эрх бүхий этгээд хууль, журамд заасан шалгуурын дагуу мэдээлэлд нууцын ангилал тогтоодог.

Мөн олон улсын жишигт “төрийн байгууллагын нууц” гэхээс илүү “**албаны нууц**”, “**захиргааны нууц**”, “**албан үүргийн нууц**” гэх ойлголтууд өргөн хэрэглэгддэг. Энэ нь мөн Монгол Улсын хууль тогтоомжийн агуулгатай адил бөгөөд уг нэршлүүд нь төрийн албан хаагчийн **албан үүргийн хүрээнд хадгалах үүрэгтэй дотоод мэдээлэл**-ийг илэрхийлдэг.

АНУ (АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС): АНУ-д **төрийн нууц** мэдээллийн ангиллыг Ерөнхийлөгчийн захиргааны ордон (цагаан ордон)-оос гаргасан *гүйцэтгэх захирамжууд* удирдлага болгодог. Одоо мөрдөгдөж буй үндсэн журам нь 2009 онд Ерөнхийлөгч Б.Обамагийн гаргасан **13526-р захирамж** бөгөөд энэ нь үндэсний аюулгүй байдлын мэдээллийг нууцлах, хамгаалах, ил болгох нэгдсэн системийг тогтоож өгсөн юм. Уг захирамжаар АНУ-ын *ангилалын гурван түвшин*—**“Нууц” (Confidential)**, **“Маш нууц” (Secret)**, **“Нэн нууц” (Top Secret)** —ийг албан ёсоор тодорхойлж, үүнээс өөр нэр томьёо хэрэглэж болохгүй гэж заасан байдаг. Иймд “Official Secret” гэх мэт бусад хэлбэрийн нэршил нь АНУ-д *албан ёсны ангиллын нэр* биш юм. Дээрх гурван зэрэглэлийн утга нь мэдээлэл задрахад үндэсний аюулгүй байдалд учрах хохирлын боломжит хэмжээгээр тодорхойлогдоно: “Нэн нууц” мэдээлэл задруулбал *онцгой ноцтой хор уршиг*, “Маш нууц” мэдээлэл задруулбал *ноцтой хор уршиг*, “Нууц” мэдээлэл задруулбал *хор уршиг* учирч болзошгүй гэж тус тус үнэлэгдэнэ гэж захирамжид өгүүлжээ. Түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол эдгээрээс бусад нэр томьёог нууцлалын зэрэг тодорхойлоход хэрэглэхийг хориглосон байна.

АНУ-д **албаны нууц** гэсэн тусгай нэршил, бие даасан хууль байхгүй ч *мэдээллийн нууцлалын дунд түвшинд хамаарах* олон төрлийн тэмдэглэгээ, журам байдаг. Төрийн байгууллагын хувьд *олон нийтэд ил биш бүхий л мэдээлэл* нь автоматаар “нууц” болдоггүй, зөвхөн үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй тохиолдолд дээрх гурван ангиллыг олгодог. Тиймээс хүний нөөц, дотоод төлөвлөгөө, санхүүгийн тайлан, internal memo зэрэг зүйлс нь ихэвчлэн *албан хэрэгцээний, эмзэг ч ангилагдаагүй мэдээлэл* гэж тооцогдоно. Ийм төрлийн мэдээлэлд хамгаалалтын дэглэм тогтоохын тулд өмнө нь “**Зөвхөн албаны хэрэгцээнд**” (**For Official Use Only, FOUO**) гэх тэмдэглэгээг өргөн хэрэглэдэг байсан ба 2010 оноос эхлэн Холбооны хэмжээнд нэвтрүүлж эхэлсэн “**Хяналттай ангилаагүй мэдээлэл**” (*Controlled Unclassified Information, CUI*) хөтөлбөрт шилжүүлсэн байдаг.

ӨМНӨД СОЛОНГОС: Өмнөд Солонгост төрийн нууцын ангиллыг ихэвчлэн “**Цэргийн нууцын хамгаалалтын хууль**”(1967 онд анх батлагдсан, сүүлд шинэчилсэн)—аар зохицуулдаг. Энэ хуулиар улсын аюулгүй байдлын ашиг сонирхолд хамаарах мэдээллийг алдагдсан тохиолдолд учрах хохирлын цар

хүрээгээр нь гурван түвшинд **ангилахыг** тодорхой заасан: “**Нэн нууц**”, “**Нууц**”, “**Итгэмжлэгдсэн**” мэдээлэл гэж. Тухайн ангиллын нэр томъёоны англи орчуулга нь олон улсын жишгээр *Top Secret, Secret, Confidential* гэж ойлгогдоно. Солонгосын армийн болон төрийн байгууллагууд энэ гурван түвшний дагуу нууцын тэмдэглэгээ хийх бөгөөд илүү нарийн дэглэм, хамгаалалтын горимыг Ерөнхийлөгчийн **зарлиг** болгон баталсан байна (ангиллын нарийвчилсан шалгуурыг тогтоосон гүйцэтгэлийн журам бий).

Энгийн төрийн байгууллагын дотоод мэдээлэл, хэрэв улсын нууцын жагсаалтад ороогүй (өөрөөр хэлбэл цэргийн болон үндэсний аюулгүй байдлын стратегийн мэдээлэл биш) бол тусгай нууцын *тамга дарахгүй*. Гэхдээ Өмнөд Солонгост бүх төрийн албан хаагчид “**албан үүргийн нууцыг хадгалах**” үүргийг хуулиар хүлээдэг нь нэг онцлог юм. Төрийн албаны тухай хуулийн 60-р зүйлд бүх албан хаагч ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн нууцыг задруулахгүй байх ёстой гэж заасан байдаг. Энэ үүргээ зөрчсөн албан хаагчид дотоод сахилгын шийтгэл (сануулах, ажлаас халах гэх мэт) оногдуулах буюу шинж чанараас нь хамаарч Захиргааны зөрчлийн тухай хуулиар торгууль ногдуулж болно. Харин нууц задруулсан үйлдэл нь улсын аюулгүй байдал, батлан хамгаалахад ноцтой хохирол учруулсан бол *Эрүүгийн хууль болон Үндэсний аюулгүй байдлын тухай хууль–ийн* хүрээнд мөрдөн шалгаж, ял оноох боломжтой байдаг.

ЯПОН: Япон Улсад нууцлалын хамгаалалт хоёр үндсэн механизмаар хэрэгждэг.

Нэгдүгээрт, үндэсний аюулгүй байдалтай холбогдох хязгаарлагдмал хүрээний мэдээллийг “Тусгайлан тогтоосон нууц” ангилалд оруулж, тусгай хууль (2013 оны Тусгай нууцын тухай хууль №108)–ээр хамгаална.

Хоёрдугаарт, бусад бүх төрийн албаны дотоод мэдээлэл нь олон нийтэд нээлттэй биш ч уг тусгай нууцын ангилалд шууд хамрагдахгүй. Энэ төрлийн мэдээлэлд тусгай тамга, зэрэглэл олгодоггүй боловч төрийн албан хаагчийн хууль ёсны үүрэг (Үндэсний олон нийтийн албан хаагчийн тухай хуулийн 100-р зүйл гэх мэт)–ээр нууцыг хадгалах зохицуулалт үйлчилдэг. Тухайлбал, яам агентлагийн дотоод тайлан, хүний нөөцийн баримт, төсвийн гүйцэтгэл зэрэг материал нь Японд “албан хэрэгцээний мэдээлэл” гэж үзэгддэг тул тусгай нууцад хамаарахгүй, гэхдээ албан хаагчид түүнийг задруулахгүй байх үүрэг хүлээдэг.

2013 оны Тусгайлан тогтоосон нууцын тухай хууль нь аюулгүй байдлын маш эмзэг мэдээллийг “Тусгай нууц” ангилалд оруулах нөхцөл, төрлийг тогтоосон байдаг. Зөвхөн Засгийн газрын сайд болон агентлагийн дарга нар хуульд заасан тодорхой чиглэлийн мэдээллийг “тусгай нууц” гэж зарлах эрхтэй бөгөөд тэдний шийдвэрээр мэдээлэлд 5 жил хүртэлх хугацаатай тусгай нууцын зэрэглэл олгодог

(энэ хугацааг дээд тал нь 30 жил, онцгой тохиолдолд 60 жил хүртэл сунгаж болох заалт бий). Тусгай нууцад хамаарах мэдээллийн чиглэл нь батлан хамгаалах, гадаад харилцаа, тагнуул, терроризмын эсрэг үйл ажиллагаа гэх мэт 4 үндсэн салбарт хуваагдсан 55 дэд төрөл зүйлээр тодорхойлогддог. Хэрэв ажилтан хууль бусаар тусгай нууц задруулбал оролцсон үүрэг, санаа зорилгоос нь хамаарч ял шийтгэнэ.

Хүснэгтээр харуулбал,

№	Улс	Төрийн нууц (улсын аюулгүй байдалтай холбоотой өндөр түвшний мэдээлэл)	Албаны нууц (дотоод, албан хэрэгцээний мэдээлэл)	Ангиллыг тогтоох субъект, эрх зүйн үндэслэл
1	ОХУ	Төрийн нууц нь улсын аюулгүй байдалд хохирол учруулах мэдээлэл; хуульд заасан салбарууд (цэрэг, тагнуул, гадаад бодлого, эдийн засаг).	Байгууллагын дотоод журам, хүний нөөц, санхүү, төлөвлөгөө г.м. “Для служебного пользования (ДСП)” гэж тэмдэглэгдэнэ.	“Төрийн нууцын тухай хууль” (1993); Засгийн газрын 1233-р тогтоол – ДСП журам.
2	Герман	4 шатлалтай: Онц нууц (Streng Geheim), Нууц (Geheim), Итгэмжлэгдсэн (VS-Vertraulich), Албаны хэрэгцээнд (VS-NfD). Улсын аюулгүй байдалд ноцтой хохиролтой бол дээд шатанд ангилна.	Дотоод баримт бичиг, албан захидал ихэнхдээ Албаны хэрэгцээнд хэрэглэдэг.	Холбооны Засгийн газрын нэгдсэн бодлого, BSI (Мэдээллийн аюулгүй байдлын холбооны алба).
3	Япон	“Тусгайлан тогтоосон нууц” (2013 оны хууль) – үндэсний аюулгүй байдалд өндөр хохиролтой мэдээлэл.	Ердийн дотоод мэдээлэл нь төрийн албан хаагчийн нууц хадгалах үүргээр хамгаалагдана. “Тусгайлан тогтоосон нууц” болон “албан үүргийн нууц” гэсэн ойлголтууд хэрэглэнэ.	“Тусгайлан тогтоосон нууцын тухай хууль” (2013), “Төрийн албаны тухай хууль”-ийн 100-р зүйл.
4	Өмнөд Солонгос	“Цэргийн нууцын тухай хууль”-д заасан 3 шат: Маш нууц, Нууц, Итгэмжлэгдсэн.	Байгууллагын дотоод мэдээлэл нь тусдаа нууцын ангилалд хамаарахгүй, харин албан хаагчийн нууц хадгалах үүргээр хамгаалагдана. “Албаны нууц” тусдаа ангилал хуульд байхгүй, харин “нууц хадгалах үүрэг” гэдэг зарчим үйлчилнэ.	“Цэргийн нууцын тухай хууль”, “Төрийн албаны тухай хууль”, “Мэдээллийн ил тод байдлын тухай хууль” (1996).
5	АНУ	Ерөнхийлөгчийн 13526-р зарлиг (2010): Нууц, Маш нууц, Онц нууц.	Хяналттай ангилаагүй мэдээлэл (CUI) тогтолцоо (2010 оноос) өмнө хэрэглэгдэж байсан “Зөвхөн албаны	Ерөнхийлөгчийн зарлигууд (13526, 13556), FOIA (Мэдээлэл олж авах эрхийн тухай хууль) .

			хэрэгцээнд” зэрэг тэмдэглэгээг нэгтгэсэн.	
6	Их Британи	2014 оноос мөрдөж буй систем: Official, Secret, Top Secret.	Official secret” гэж хуульд (Acts) хэрэглэдэг – төрийн бүх байгууллагуудын өдөр тутмын мэдээллүүд.	Засгийн газрын Тамгын газар (Cabinet Office), “Official Secrets Act” (1911, 1920, 1939, 1989) – задруулсан тохиолдолд ял шийтгэл оногдуулдаг.

Түүнчлэн, Төрийн болон албаны нууцын эрх зүйн зохицуулалт: Олон улсын чиг хандлага, зарим улсын туршлага” сэдэвт харьцуулсан судалгааны ажилд “Сингапур, Молдав, Их Британи, Малайз, Эстони, Герман, Япон, Солонгос зэрэг улсын төрийн нууцын хууль тогтоомжид “албаны нууц” гэх ойлголт тусгагдаагүй байна.⁵

Улс орнуудын төрийн нууцын харилцаанд холбогдох хууль тогтоомжийг судалж үзэхэд, Европын холбооны гишүүн орнуудын хувьд хязгаартай (restricted), нууц (confidential), маш нууц (secret), онц чухал нууц (top secret) гэсэн 4 түвшинт нууцлалын тогтолцоог жишиг болгон баримталж байна.

Гэхдээ “албаны нууц” гэсэн ойлголтыг огт тусгаагүй. Түүнчлэн Хонконг, Их Британи, Малайз зэрэг оронд “Official secrets act” нэртэй хууль үйлчилж байгаа боловч улсыг батлан хамгаалах, тагнуул, гадаад харилцаа зэрэг асуудлаар төрийн нууцын хүрээ хязгаарлагддаг.⁶” гэжээ.

Иймд дээр дурдсан үнэлгээнд үндэслэн Монгол Улсын Үндсэн хуульд заасан мэдээлэл хайх, хүлээн авах иргэний үндсэн эрхийг хангах, “Транспаренси Интернэшнл” олон улсын байгууллагаас жил бүр гаргадаг Авлигын төсөөллийн индексийн оноог сайжруулах, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн зохицуулалтыг эргэн харж, албаны нууцын талаарх ойлголтын хүрээг хумих, нууцад авах шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох зорилгоор Төрийн болон албаны нууцын тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

---oOo---

-

⁵ Судалгааны тайлангийн эмхэтгэл XVII боть (2024 он), 312 дахь тал.

⁶ Судалгааны тайлангийн эмхэтгэл XVII боть (2024 он), 323 дахь тал.

Эх сурвалж:

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2022), №6;
- Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №11;
- Төрийн нууцын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1995), №7;
- “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал;
- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- ОХУ, “Төрийн нууцын тухай” хууль болон ДСП журам—ru.wikipedia.org/profiz.ru;
- Герман, нууцлалын түвшин VS-NfD, албан нууц (Dienstgeheimnis)—utimaco.com/coe.int;
- Япон, Үндэсний албан хаагчийн хууль 100-р зүйл, Тусгай нууцын хууль — apjif.org/en.wikipedia.org;
- Өмнөд Солонгос, Цэргийн нууцын хууль 3-р зүйл, Төрийн албаны хууль 60-р зүйл — elaw.klri.re.kr/elaw.klri.re.kr;
- АНУ, CUI хөтөлбөр, FOUO/SBU нэгтгэх—en.wikipedia.org, мөн ангиллын систем —en.wikipedia.org;
- Их Британи, Government Security Classifications Policy, Official Secrets Act 1989—en.wikipedia.org/en.wikipedia.org.